



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 256

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, 2022 оны 204 дүгээр тогтоолын 1, 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн 8 нэрийн, нийт 982,651,400.00 (есөн зуун наян хоёр сая зургаан зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ, 603.786.343,14 (зургаан зуун гурван сая долоон зуун наян зургаан мянга гурван зуун дөчин гурван төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Л.Алтангэрэл, тогтоолын хавсралтад заасан байгууллагуудын дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

ЗСХ-Г

(Handwritten signatures)



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 08 дугаар сарын 08 ны өдрийн
 15.6 Дугаар албан бичгийн хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгө шилжүүлэх байгууллагын нэр	Автомашини марк улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын нийт үнэ	Хуриимтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
						(төгрөг)	
1	Оюуны өмчийн газар	Соната-8 58-59УБУ	КМНЛ3416ВЛА03 9753	2019	72,800,000.00	21,233,333.45	51,566,666.55
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	Соната-8 03-19УБГ	КМНЕ341СВJA46 7916	2019	95,550,000.00	21,498,750.00	74,051,250.00
3	Хөдөө аж ахуйн бирж ХХК	Ландкрудер-200 07-17УНР	JTMNH05J504049 865	2013	151,226,400.00	132,302,384.07	18,924,015.93
4	Дулааны цахилгаан станц 4 ТӨХК	Ландкрудер-200 61-88УБМ	JTMNH05J704123 528	2017	137,275,000.00	59,362,162.25	77,912,837.75
5	Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ	Ландкрудер-200 14-41УНУ	JTMNH05J904123 675	2017	200,000,000.00	173,071,657.92	26,928,342.08

6	Монгол Улсын Хөгжлийн банк	Ландкрузер-200 09-18УББ	ЈТМНХ05Ј904074 512	2014	176,000,000.00	135,862,222.22	40,137,777.78
7	Үндэсний давхар даатгал ХК	Старекс Н-1 07-52УБГ	КМЈWA37RBKU0 71468	2019	94,900,000.00	24,515,833.23	70,384,166.77
8	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	Соната-8 72-99УБГ	КМНЕ241САGA2 58719	2016	54,900,000.00	35,940,000.00	18,960,000.00
НИЙТ ДҮН					982,651,400.00	603,786,343.14	378,865,056.86
					(есөн зуун наян хоёр сая зургаан зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун)	(зургаан зуун гурван сая долоон зуун наян зургаан мянга гурван зуун дөчин гурван төгрөг арван дөрвөн мөнгө)	(гурван зуун далан найман сая найман зуун жаран таван мянга тавин зургаан төгрөг наян зургаан мөнгө)